

Хувцасны СТИЛЬ



Стиль-stylus /хэв маяг/

- Style нь хувцас загварын ертөнцөд их өргөн цар хүрээтэй ойлголт юм. Загварын хөгжлийн явцад хүмүүсийн өргөн сонголт, сонирхол хэрэгцээнээс хамааран бий болон тогтсон үндсэн стиль байдаг.

Luxury style

- Хэрэгцээнээс хэтэрсэн тансаг хээнцэр /дэлхийд алдартай том брэндийн/ загварууд хамаарна. Ийм загварын хувцас, чимэглэл хэрэглэлүүдийг зайлшгүй хэрэглэх зүйл биш ч ямар ч хүний шуналыг хөдөлгөм тансаг гоёмсог байдал нь баячуудыг татаж хэрэглэгчээ болгож чаддаг.

Classic style

- Эрт үеэс одоог хүртэл болон цаашид үргэлжлэн аль ч үеийн хүмүүсийн сонголт хэрэгцээ болж чадсан загварууд хамаарна. Сонгодог стильд хар, цагаан, улаан, саарал, хөх, хүрэн гэсэн өнгөнүүд хамаарахаас гадна хүн бүхний мэдэх сонгодог загварын брюкэн өмд, костюм, жакет, жилетик... зэрэг хамаарна.

Elegant style

- Гоё дэгжин, ганган дээд зэрэглэлийн харагдуулж чадах өнгө дизайн бүхий загварууд энэ стильд хамаарна. Жишээ нь: Олны танил одуудаас энэ стилийг Николь Кидмэн, Жорж Куллони зэрэг одуудаас харж болно.

Vintage style

- Үнэд орсон хуучны эдлэл мэт сэтгэгдэл төрүүлэм загваруудыг винтаж стильд хамааруулна. Гэхдээ хуучирч урагдаж удсан хувцас гэсэн үг биш шүү. Жишээ нь удаан эдэлсэн мэт харагдах цайралт өгсөн савхин хувцас, сэмэлж цацагласан жинсэн өмд ... ГЭХ МЭТ.

Chic style

- Байгаагүй зүйлийг цоо шинээр бий болгосон биш боловч тухайн үедээ шинэлэг өвөрмөц байдлыг илтгэж чадаж буй стилийг ингэж нэрлэдэг.

Modern style

- Залуу орчин үеийн өнгө аясыг илтгэсэн өнгө загвар бүхий стиль юм. Тухайн амьдарч буй үетэйгээ хөл нийлүүлэн алхаж ирээдүйд тэмүүлэгч сэтгэлгээтэй залуучуудын сонголт.

Casual style

- Нэг их анхаарал тавилгүй санаандгүй л шүүрээд өмсчихдэг биед эвтэйхэн авсаархан загварууд хамаарна. Загвар стильд анхаарал тавьдаггүй энгийн хүмүүс ихэвчлэн гол хэрэглэгчид нь байдаг. Гэвч ойр зуурт хүн болгон л энэхүү стилийг сонгодог болохоор өргөн хэрэглэгчидтэй гэж болох юм.

Romantic style

- Дэврүүн, сэтгэл хөдөлгөм гоёмсог өнгө дизайн, чимэглэл бүхий загварууд хамаарагдах стиль. Хувцасны материал нь ихэвчлэн шиффон, сिल्к, нимгэн торгомсог байх бөгөөд цэцэг, хуниас болон торон туузан чимэглэл зэргээр чимсэн загварууд. Үүнээс ч хамаарч энэхүү стилийн хэрэглэгчид ихэвчлэн эмэгтэй хүмүүс байдаг.

Office style

- Албан болон хувийн байгуулагуудын оффист ажилладаг хүмүүсийн сонголт. Сонгодог өнгө, загвар бүхий болон хэт хурц бус, хэт задгай чөлөөт загвартай бус хийц загвар сайтай, цэмцгэр загварын хувцаснууд хамаарна.

Sport style

- Спорт брэндүүдийн эрүүл мэнд болон биед эвтэй байдлын хэрэгцээг хангасан спорт загварын хувцаснууд хамаарна. Залуу үеийнхэн өргөн сонгож хэрэглэдэг.

Hippie style

- Энэ стилийн үүссэн он цаг нь тодорхойгүй ба Хиппи гэж нэрлэх болсон. Учир нь Нью-Йоркын нэг телевизийн сувгаар урт үс, уранхай жинс, том майк өмссөн Хиппи хэмээх хамтлагийн залуус 1959 онд эхлэн 1973 онд дууссан Вьетнамын дайныг эсэргүүцэн бослого гаргаж байхыг сурвалжлан олон нийтэд цацжээ. Энэ цагаас л хойш том майк, уранхай жинс өмсөж бослого гаргадаг залуусыг хиппичууд гэж нэрлэх болсон. Хиппи гэдэг үг нь бол Америкийн хар ярианаас үүсэлтэй үг ба албан ёсны буюу уламжлалт соёлыг эсэргүүцэгч, ардчилалыг хэт хамгаалагчид гэсэн утгатай үг юм.

Хиппи нь анх гарч ирэхдээ хувцасны стиль гэж явдаггүй байсан бөгөөд хүмүүс ойлгохдоо гэр оронгүй, гэр бүлгүй замбараагүй амьдралтай хүмүүсийг л хиппи хэмээн нэрлэдэг гэсэн хэт туйлширсан бодолтой байжээ. Сонгодог хувцас нь маш үнэтэй материалаар хийгддэг зөвхөн дээдсийн хүрээний хүмүүст л зориулагдсан хийхэд нарийн эсгүүрийн арга ёс жаягийг дагадаг байлаа. Харин хиппи стилийн хувцаснууд нь Ази, Африк, Цыган үндэстнүүдийн хувцасны хэлбэр, өнгө орнамент зэргийг хольж, зах зээлээс маш хямдхан материалаар хийгдэж үүгээрээ өөрсдийн эрх чөлөөг илэрхийлж байсан гэдэг.


Хиппи стилээр хувцасладаг хүмүүс нь ямар нэг компанийн лого шошготой хувцас өмсдөггүй ба зөвхөн өөрийн гараар хийсэн эсвэл цор ганц захиалан хийлгэсэн хувцсыг өмсдөг. Хиппичүүд нэг авсан хувцсаа хэзээ ч хаядаггүй жил болгон тухайн хуучин хувцсаа шинэ хэв маяг оруулан өмсдөгт оршино. Бас хиппичүүдийн гол үндсэн шинж нь байгаль эколигот санаа тавьж зөвхөн байгалийн гаралтай хувцас өмсөхийг эрхэмэлдэг.













ULZZANG

ULZZANG нь Солонгос улсаас гаралтай үг юм. Энэ нь эхэндээ EOLJJANG байсан бөгөөд явцдаа ULJJANG буюу ULZZANG болжээ. Энэхүү үгийг орчуулбал **The best face in korea/The best face in the world** гэсэн утгатай үг юм. (Солонгос дах хамгийн хөөрхөн нүүр царай/ Дэлхий дэх хамгийн хөөрхөн нүүр царай)

- ULZZANG охид хөвгүүд бүгд өнгө өнгийн линз зүүдэг бөгөөд том нүд, цайвар цагаан царайтай байдаг. Гадаад ULZZANG-ууд нь онцгой өвөрмөц үсний засалттай байдаг. Харин монгол охид хөвгүүд дунд сонин содон засалттай нь ховор байдаг боловч тэгш, далий чолк гаргасан байдаг. ULZZANG нь Барууны орнуудад байдаггүй.

- **Үс засалт**

Хэвийн урт үсийг ямар нэг содон үс засалтанд оруулдаг. Ихэвчлэн bun буюу /үсээ хонгорцоглож шуух, үсээ дээш шууж боох/ мөн тал самнасан bun/сул bun/ үсний засалттай байдаг. Ulzzang өөр засалтыг хүсч байвал буржгар үс, долгионтой үс үүнээс гадна маш олон сонирхолтой үс засалт байдаг.

- **Нүүр царай**

Ulzzang-ууд ихэвчлэн том нүд, цэвэрхэн арьс, жижиг ам хамартай байдаг. Энэ нь тэдний гол үндсэн төрх байдаг. Ихэвчлэн ULZZANG охид хөвгүүд ихэнхдээ өнгө өнгийн Линзийг голчилж зүүдэг.

- **Хувцаслат**

Чөлөөт загварын өнгөлөг өнгөтэй хувцас өмсдөг ба хувцасны загварууд нь Солонгосын загварын сэтгүүлд байдаг

Ихэнхи улззангууд “Haduri”-г хэрэглэдэг энэ нь өөрийнхөө зургийг авч вэб сайтад байрлуулах юм. Ихэнхи алдартай улззангууд бүгд олны танил од болсон байдаг. Зарим нь нэвтрүүлэгт уригдаж, сэтгүүлд ч зургаа татуулдаг. Харин зарим нь жүжиглэх, уулзах, загвар өмсөх гээд карьераа хөөдөг байна.


zzang нэр нь;

- Ulzzang / 얼짱 : Царайн дээр тулгуурласан. “нүүр царай” гэсэн утгатай.
- Momzzang / 몸짱 : Биен дээр тулгуурласан. “Бие” гэсэн утгатай./Хамгийн сайхан биетэй хүмүүс/

Ahn Jaehyo (*Block B*)




Lee Kiseop (*U-KISS*)



Choi Jonghun (*FT Island*)



Jang Hyunseung (*B2ST*)



Heo Youngsaeng (*SS501*)



Oh Sehun (*EXO*)



Park Chanyeol (*EXO*)



Kim Himchan (*B.A.P*)




Kim Sungje (*Supernova*)



Jung Yonghwa (*CN BLUE*)



Kim Ryeowook (*Super Junior*)



Hwang Juwon (*Double A*)



Gong Chanshik / Gongchan
(B1A4)



Lee Jonghyun (CN BLUE)



Kim Myungsoo / L (*Infinite*)

)



Goo Hara (*KARA*)



Shin Yoonjo (*Hello Venus*)



Kwon Mina (*AOA*)



Jin Hyewon (*Co-Ed School*)



Lee Jihyun / Q-ri (*T-ara*)




Park Sunyoung / Hyomin (T-ara)



Kim Ahyoung / Yura (Girl's Day)











Swag-"Гадаад төрх.стиль,тухайн хүний өөрийн илэрхийлэл

- Свэг хэмээх үг нь маш олон хэл, маш олон мэргэжлийн хэллэгт өөр өөрөөр орчуулагддаг. Жишээ нь Австралийн хэл бичгийн толинд "өмч хөрөнгөө баглах" харин мэргэжлийн үг хэллэг дээр радиогийн нэвтрүүлэгчид шагналтай бараа сурталчилгааг свег гэж нэрлэдэг байна. Мөн Америкийн 30,40 оны хулгайчид өөрсдийн хулгайсан цүнх, хувцсыг мөн Свэг хэмээн нэрлэдэг байжээ. Гэхдээ анх Свэг гэдэг үгийн үүсэл гарал нь Скандинавчуудын Svagga (найгах,ганхах) гэсэн үгнээс гаралтай гэж хэл шинжээчид үзсэн байна.





Fashiony.ru



Fashiony.ru







MY SWAG SET FOR SCHOOL





OWL MANIA



Fashiony.ru



Fashiony.ru



Fashiony.ru

WIN THIS
ANTHROPOLOGIE




Fashiony.ru















Fashiony.ru





Fashiony.ru



Fashiony.ru





*Women
rule the world
Men are just here
for the company*



Fashiony.ru











Fashiony.ru





Fashiony.ru





